



**Тогтвортой хөгжихүйц боловсролын үзэл  
санааг боловсролын бодлого төлөвлөлтөд  
тусгах нь**

**Б.Тунгалаг**

*/МУБИС-ийн багш, дэд профессор/*

# АГУУЛГА

---

1. Тогтвортой хөгжлийн боловсролын талаарх ойлголт
2. ББИДСОУС – ийн үндсэн үйл ажиллагаа
3. Боловсролын талаар зөвлөмж боловсруулахад баримталдаг зарчмууд
4. ТХБ-ын үзэл санааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
5. ТХБ-ын үзэл санааг сургалтын агуулгад тусгах нь

# Тесалоникийн тунхаглал 1997

- “Хүрээлэн буй орчин ба нийгэм” сэдэвт олон улсын бага хурал
- “Боловсрол ба олон нийтийн мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх” тухай Тесалоникийн тунхаглал
- Энэ тунхаглалд тогтворжилт нь нийгмийн бүх шатанд байгалтайгаа харилцан уялдаатай явагдах ёстой хэмээн тэмдэглэжээ.

# Тогтвортой хөгжил

- ядуурал, хүн ам, хүнсний аюулгүй байдал, ардчилал, хүний эрх, эрүүл аж төрөх, уламжлалт соёлын болон экологийн мэдлэгийг хүндэтгэж үзэх гэсэн ойлголтуудтай холбон авч үзэх хэрэгтэй гэж үзсэн

- **Албан боловсролоор** судалж буй хичээлийн агуулгад
  - хүрээлэн буй орчин болон тогтвортой хөгжлийн талаарх ойлголтыг тусгах,
  - мөн аливаа зүйлийг *өөр хооронд нь харилцан хамааралтай авч үзэх* гэсэн санааг их, дээд сургуулиудын *сургалтын хөтөлбөрт суулгаж* өгөх хэрэгтэй гэсэн санаануудыг онцлон тэмдэглэсэн байна.

# “ТХБ-ын үзэл санаанд тулгуурлан багш боловсролыг шинэчлэх” баг

- Канад улсын Торонто хотын Ёоркийн их сургууль дээр ЮНЕСКО-ийн боловсрол хариуцсан тусгай албыг байгуулсан.
- Багш бэлтгэдэг 28 орны нийт 30 гаруй их дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн “Багш Бэлтгэдэг Их Дээд Сургуулиудын Олон Улсын Сүлжээ”-г (ББИДСОУС) үүсгэн байгуулсан.

# ББИДСОУС –ний үндсэн үйл ажиллагаа (1)

- Багш боловсролыг шинэчлэхэд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн талаар ямар сэдвийг, ямар хэлбэрээр шинээр нэмж оруулах, хэрхэн тусгаж хэрэгжүүлэх

## Con't (2)

- Боловсролын бодлого төлөвлөлтийн түвшинд ямар үйл ажиллагааг явуулж, хэрхэн хэрэгжүүлэх
- Тухайн улс үндэстэн, бүс нутаг, орон нутгийн хүрээлэн буй орчны болоод нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад багш боловсролын гүйцэтгэх үүрэгт дүн шинжилгээ хийх



## Con't (3)

- Сургалт-үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ, сургалтын хөтөлбөр, заах аргазүй, практик үйл ажиллагаа, мэдээллийн технологи, хамтын ажиллагаа, түншлэл, холбоо харилцааг сайжруулах мөн түүнчлэн боловсролын талаар хэрэгжүүлж буй бодлогын талаар удирдамж, зөвлөмжийг боловсруулан гаргаж, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион явуулдаг.

## Боловсролын талаар зөвлөмж боловсруулахад баримталдаг 7 шалгуур

1. ТХБ нь тухайн орон нутгийн соёлын онцлогийг харгалзсан байх
2. ТХБ нь тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх, гэхдээ дэлхий нийтийн чиг хандлагыг тусгасан байх
3. ТХБ-ын үзэл санаа нь албан ба албан бус боловсролын агуулгад туссан байх
4. ТХБ нь хөгжлийг тасралтгүй, тогтвортой байлгахад чухал үүрэгтэй байх

5. ТХБ нь “тогтвортой байдал” ойлголтын мөн чанарыг тусгасан байх
6. ТХБ-ын үзэл санаа нь сургалтын агуулга, түүний хамрах хүрээ, аргазүйд туссан байхаас гадна дэлхий нийтийн чиг хандлага төдийгүй тухайн орон нутгийн тэргүүлэх чиглэлтэй уялдаж байх
7. ТХБ нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн байх

# ТХБ-ын үзэл санааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8 чиглэл

1. Улс үндэсний түвшинд (яам, тамгын газрын оролцоог нэмэгдүүлэх)
2. Бүс нутгийн түвшинд (аймгийн боловсрол соёлын газар, сургуулийн оролцоог нэмэгдүүлэх)
3. Дээд боловсролын байгууллагын түвшинд
4. Санхүүжилт, төсөв бүрдүүлэх

5. Хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх
6. Судалгаа шинжилгээний ажлыг дэмжих
7. Харилцаа холбоог хөгжүүлэх
8. Мэдээллийн технологийг нэвтрүүлэх

# 1. Улс үндэсний түвшинд (яам, тамгын газрын оролцоог нэмэгдүүлэх)

- Яам, тамгын газрын боловсрол хариуцсан мэргэжилтнүүд хамтарч ажиллан тухай бүс нутгийн онцлогт тохирсон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санааг тусган, шинэчлэх
- Багш бэлтгэх болон багшлах эрх олгох сургалтын агуулгыг ТХБ-ын үзэл санаанд тулгуурлан шинэчлэх (бага, дунд боловсролын сургалтын агуулгад нийцүүлэн өөрчлөх)
- ТХБ-ын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх талаар хамтарч үйл ажиллагаа зохион явуулах
- Багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийг дээшлүүлэх сургалтын агуулгад ТХБ –ын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх
- ТХБ-ын үзэл санааг хэрэгжүүлэхэд багш нарын холбоодын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх
- ТХБ –ын үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх (их дээд сургуулиуд, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх)
- Үндэсний хэвлэх үйлдвэрүүд болон бүх шатны сургуулийн сурах бичиг зохиогчдын хамтын ажиллагааг дэмжих

## 2. Бүс нутгийн түвшинд (аймгийн боловсрол соёлын газар, сургуулийн оролцоог нэмэгдүүлэх)

- Сургалтыг судалгаа-үйлдвэрлэлтэй уялдуулах, тухайлбал, төрийн бус байгууллагууд, бизнесийн агентлагууд, сайн дурын клубуудтай хамтран танхмийн болон хичээлээс гадуурх сургалтыг зохион явуулах
- Багшлах дадлага болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг нийгэм рүү чиглэсэн үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулах (дадлагын оюутнууд нь үйлийн явцдаа суралцаж, тодорхой мэдлэг, чадвар, аргазүйг эзэмшиж авах)
- Боловсрол хариуцсан мэргэжилтнүүд болон заах аргазүйчид хамтраад тухайн бүс нутгийн онцлогт тохирсон “ТХБ модуль”-ийг боловсруулж, сургалтад нэвтрүүлэх
- Бүс нутгийн хүрээнд ТХБ судалгааны багийг бүрдүүлж, багш боловсролын шинэчлэлийг дэмжиж ажиллах, орон нутгийн хэмжээнд сурталчлах, хэрэгжүүлэх
- Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, ТХБ-ын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх

### 3. Дээд боловсролын байгууллагын түвшинд

- *А. их, дээд сургуулиудын оролцоог нэмэгдүүлэх* - сургалтыг судалгаа үйлдвэрлэлтэй уялдуулах, ТХБ-ын үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд тухайн сургуулийн бүрэлдэхүүн сургууль, багш нар, судлаач, сургалтын менежерүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, сургалт нь суралцагчийн тасралтгүй, тогтвортой хөгжих байдлыг хангахад чиглэгдсэн байх (interdisciplinary courses), оюутны холбоотой хамтарч ажиллах, оюутны оролцоог нэмэгдүүлэх



- ***Б. факультет / бүрэлдэхүүн сургуулиудын оролцоог нэмэгдүүлэх*** – бүрэлдэхүүн сургуулиудын захирал, сургалтын менежерүүд нь ТХБ-ын талаар нэгдмэл ойлголттой байх, багш бүр нь ТХБ-ын хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг танин мэдсэн байх, мөн түүнчлэн ТХБ нь багш боловсролд тэр дундаа суурь боловсролын чанарыг сайжруулах, өнөөгийн багш боловсролыг шинэчлэхэд ямар үүрэг гүйцэтгэж байгаад анализ хийх чадвартай байх, багш боловсролыг шинэчлэхэд багш бүрийн оролцоог нэмэгдүүлэх, тухайн бүрэлдэхүүн сургуульд боловсролын шинэчлэлийг нэвтрүүлэх зорилгоор ТХБ төслийг санаачилж хэрэгжүүлэх, тэргүүний багш, судлаач, тэнхэм шалгаруулах шалгуурыг ТХБ-ын үзэл санаанд тулгуурлан шинэчлэн боловсруулах<sup>27</sup>

- ***В. багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг өөрчилж шинэчлэх*** – сурган хүмүүжүүлэх арга технологийг өөрчлөх (сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, асуудал шийдвэрлэх арга барилд сургах, сурагч бүрийн идэвх оролцоог нэмэгдүүлэх), сурагчдыг хүйс, арьсны өнгө, угсаа гарлаар нь ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн тэнцвэртэй байдлыг хэрхэн хангаж амьдрах талаар ойлгуулах, оюутнуудаар сургалтын хөтөлбөр боловсруулж, туршиж хэрэгжүүлэх, багш болох оюутанд зориулсан ТХБ модулийг боловсруулах

## 4. Санхүүжилт, төсөв бүрдүүлэх

- Боловсролын яамтай хамтран ажиллах, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, судалгааны төсөл бичиж, хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчин болон нийгмийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, их, дээд сургуулиудтай хамтран судалгаа шинжилгээний төсөл хэрэгжүүлэх

## 5. Хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх

- Багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд, бага, дунд сургуулиуд, музей, байгаль хамгаалах мэдээлэл сурталчилгааны төвүүд хоорондын хамтран ажиллагааг өргөжүүлэх, олон улсын болоод үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн төслийн үр дүнтэй танилцаж, туршлага солилцох,

## 6. Судалгаа шинжилгээний ажлыг ДЭМЖИХ

- Судалгааны үндсэн хөтөлбөртэй байх, онол-практикийг хослуулах, сургалтын чанарыг дээшлүүлэх талаар судалгаа хийх, үнэлгээний стандартыг судлан шинэчлэх, ТХБ-ын үзэл санаанд тулгуурлан бүх шатны сургалтыг шинэчлэх үйл явцыг эдийн засгийн талаас нь авч үзэх, судлах

## 7. Харилцаа холбоог хөгжүүлэх

- ТХБ-ын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх тэргүүн туршлагаа хэвлэн гаргаж, бусадтай хуваалцах, өгүүлэл бичиж хэвлүүлэх, судалгааны болон төслийн тайланг мэргэжлийн болон боловсролын байгууллагуудад танилцуулах, орон нутгийн болон үндэсний чуулганд илтгэж, хэлэлцүүлэх, хэвлэл мэдээллийн албатай хамтран ажиллаж, ТХБ-ын талаар хийсэн үйл ажиллагааг сурталчлах

## 8. Мэдээллийн технологийг нэвтрүүлэх

- ТХБ-ын үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд мэдээллийн технологийг хэрхэн ашиглах талаар гарын авлага боловсруулах, онлайн болон зайны сургалтыг амжилттай зохион явуулах зөвлөмж боловсруулах, МТ-ийг ашиглан багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, МТ ашиглан суралцагчдын сурах арга барилыг тодорхойлох

**Тогтвортой хөгжлийн  
боловсролын үзэл санааг  
сургалтын агуулга  
тусгах нь**




# Зорилго

- ✓ ТХБ – ын үзэл баримтлалыг сургалтанд тусгах хэрэгцээ, шаардлага юу вэ?
- ✓ ТХ-ийн үзэл санааны дагуу боловсролын шинэчлэлд бид юуг анхаарах ёстой вэ?
- ✓ ТХБ-ын үзэл санааг мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах боломжийг эрж хайх

# Шилжилтийн үе

ᠠᠶᠢᠨᠠᠳᠠᠨᠠᠳᠠᠨᠠᠳᠠᠨ

ᠡᠳᠦᠭᠦᠨᠠᠳᠠᠨ



Багш,  
сурагч

Багш төвтэй

Уулзалт

ᠣᠣᠴᠡᠢ ᠴᠠᠠᠠᠳᠠᠳ

ᠥᠢᠭᠦ ᠴᠠᠠᠠᠳᠠᠳ

# Боловсролын зорилго

Эрүүл  
чийрэг бие  
бялдар

Хүмүүнлэг  
ёс  
суртахуун

Оюуны  
зохих  
чадавхи

Гоо  
сайхны  
мэдрэмж  
таашаал

<b>Үзүүлэлт</b>	<b>Уламжлалт хандлага</b>	<b>Орчин үеийн хандлага</b>
<b>Хүн</b>	Тухайн нийгмийн зорилгодоо хүрэх арга хэрэгсэл	Нийгмийн хөгжлийн гол зорилго, үнэт зүйл
<b>Боловсролын агуулга</b>	Мэдлэг эзэмших үйл явц	Хүн төлөвших үйл явц
<b>Боловсролын зорилго</b>	Нийгмийн зорилгод нийцсэн хүнийг бэлтгэх	Нийгэм-соёлын аливаа орчинд амьдрах чадвартай иргэн төлөвших
<b>Боловсролын үүрэг</b>	Хүнийг нийгэмшүүлэх, мэргэжил олгох	Хүний хөгжих, төлөвших нөхцөлийг бүрдүүлэх
<b>Хүний гол эрхэмлэл</b>	Нийтээр дагаж мөрдөх норм, хэм, хэмжээнд нийцэх	Бие даан бүтээлчээр амьдрах

## Багшийн зорилго

Боловсролын үзэл  
санааг сургалт  
явуулж буй  
практиктаа  
тусган, бодитой үйл  
хэрэг болгох

## Хэрэгжилт, оролдлого

Боловсрол олгож  
буй чиг шугам, арга  
зарчимдаа дүн  
шинжилгээ хийх

Сургалтын арга  
хэлбэрээ  
шинэчлэх, өөртөө  
үнэлгээ өгөх

- ❖ ТХБ олгох асуудлыг зөвхөн багш нарт даатгах уу?
- ❖ Дунд сургуульд эзлэх хувь нь ямагт их байдаг байгалийн ухааны хичээлээр ТХБ-ыг хэрхэн олгох вэ?
- ❖ Хичээл, сургалтаар ТХБ-ыг хэрхэн олгох вэ?
- ❖ Суралцагчдын амьдрах хэв маяг, ертөнцийг үзэх үзэлд хэрхэн нөлөө үзүүлж болох вэ?

## ТХБ-ЫН ЗОРИЛГО

- Ёс суртахууныг гол шалгуур болгох
- Хүн төрөлхтнийг даяар шинжтэй аюулаас өөрийн бүхий л бололцоогоор сэргийлэх эрхэмлэл, хариуцлагатай болгох
- Шинэ эрин үед шаардагдах ёс зүйн хэм хэмжээг түгээн дэлгэрүүлж, төлөвшүүлэх боловсролтой болгох

# Хичээл, сэдэв бүрийн агуулгатай холбох үзүүлэлтүүд

**Хүмүүнлэг ёс  
суртахуун**

**Нийт хүн төрөлхтний  
үнэлэмж, “амьдралыг”  
үнэт зүйл гэж үзэх  
эрхэмлэлд суурилсан  
хариуцлага**

**Монгол  
ахуйн  
онцлог,  
уламжлалт  
соёл**



# Хичээл, сэдэв бүрийн агуулгатай холбох үзүүлэлтүүд

**Хүмүүнлэг ёс  
суртахуун**

**Нийт хүн төрөлхтний  
үнэлэмж, “амьдралыг”  
үнэт зүйл гэж үзэх  
эрхэмлэлд суурилсан  
хариуцлага**

**Монгол  
ахуйн  
онцлог,  
уламжлалт  
соёл**

# 1. Хүмүүнлэг ёс суртахуун

Ёс суртахууны боловсрол олгож байгаа  
өнөөгийн байдал нь:

- Ёс суртахууныг зөвхөн хүмүүсийн хоорондын эелдэг харьцаа төдийхнээр хязгаарлаад байх уу?
- ЕБС-д ёс зүйн хичээл орсноор сурагчдыг ёс суртахуунтай болж байна гэж санаа амарч болох уу? гэсэн асуудалд хүргэдэг.

## *2. Нийт хүн төрөлхтний үнэлэмж, “амьдралыг” үнэт зүйл гэж үзэх эрхэмлэлд суурилсан хариуцлага*

- ❖ Шударга ёс, сайн, сайхан үйл, энх тайван, ардчилал, үнэн, эв нэгдэл, эрх чөлөө гэх мэт үнэт зүйлсийн төлөө аль ч ард түмэн тэмцсээр ирсэн түүхтэй.
- ❖ Харилцан шүтэлцээтэй эх дэлхийн зүй тогтолд хүндэтгэлтэй хандах, байгалиа нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, тэсэж үлдэх зорилго ч энэ эрин үеийнхний эрхэмлэл, үнэт зүйл мөн.

### *3. Сургалтыг монгол ахуйн онцлог, уламжлалт соёлтой холбох нь*

Монголчууд ёс суртахуун, хэв заншлын сургаал, түүний тогтолцоог хамгаас ихээр эрхэмлэн үзэж, амьдралаа зохицуулах үндэс болгон хэрэглэж ирсэн түүхтэй. Монголын ард түмэнд залуу үеэ хөгжүүлж, төлөвшүүлж байсан эртний өв уламжлал, байгальтай зохицон аж төрдөг амьралын өвөрмөц арга ухаан, эв найрыг эрхэмлэгч нандин заншил бүгд бий. Энэ бүхнийг өвлүүлж байсан арга ухааныг нь сайтар судалж, өөриймүүлэх нь улс түмний зохицон амьдрах, ханьсан аж төрөх болсон эдүгээийн нөхцөлд олон асуудлын шийдэлд ач холбогдолтой.

# Хичээл, сэдэв бүрийн агуулгатай холбох үзүүлэлтүүд



Хэрхэн, ямар арга замаар холбох вэ? Учир нь эдгээр үзүүлэлт бүхэн нь багшийн тусгайлан гарчиглаж, заах сэдэв биш, ухуулга, сурталчилгаа ч биш, харин аливаа сургалтын үр дүн нь болох ёстой юм.

# Дүгнэлт

- Боловсролын шинэчлэл нь багш боловсролоос эхэлнэ.
- ТХБ-ын зорилгыг хэрэгжүүлэхэд өнөөгийн багш бэлтгэх сургалтыг бүхэлд нь хувирган өөрчлөх шаардлагатай хэмээн үзэж байна.
- Сургуулийн дотоод мөн чанар (сургуулийн зохион байгуулалтын зарчим, үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр), бүтцийг ТХБ-ын үзэл санаанд тулгуурлан өөрчлөх шаардлага нэн тэргүүн тулгараад байна хэмээн Нэгдсэн Үндэсний Байгууллагынхан дүгнэжээ.<sup>38</sup>